



ХЭНТИЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ГУРАВДУГААР ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2024 оны 12 сарын 19 өдөр


Дугаар 04

Чингис хот

Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл  
ажиллагааны хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалт, Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Гуравдугаар Хуралдаанаас ТОГТООХ нь:

- Хэнтий аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
- Хөтөлбөрийн санхүүжилтийг аймгийн төсөвт тусгаж, хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулж, дүнг жил бүр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга (Д.Аюурбуунь)-д даалгасугай.
- Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүй, Нутгийн удирдлагын хороо (Д.Батболд)-нд үүрэг болгосугай.



Хэнтий аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын 2024 оны 12 дугаар сарын 19-ний  
өдрийн 03 дугаар хуралдааны  
04 дүгээр тогтоолын хавсралт

Хэнтий аймгийн Засаг даргын 2024-2028 оны  
үйл ажиллагааны хөтөлбөр

## НЭГ. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Хот, хөдөөгийн тэнцвэрийг хангах бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, иргэдэд таатай, эрүүл, аюулгүй, байгаль орчинд ээлтэй төвүүдийг хөгжүүлнэ.

### 1.1. БҮСИЙН ХӨГЖИЛ

1.1.1. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг дэмжинэ.

1.1.1.1. "Түүхэн аялал жуулчлалын төрөлжсөн бус бөгөөд эрчимжсэн хөдөө аж ахуйн дэд бус" болох суурь дэд бүтцийг байгуулна.

1.1.1.2. "Өндөрхаан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-нд тодотгол хийж, үйлдвэрлэл, үйлчилгээ, тээвэр, логистик, дэд бүтцийн хөгжил бүхий иргэдийн амьдрах таатай орчныг бүрдүүлсэн "Чингис хот"-ыг хөгжүүлнэ.

1.1.1.3. Сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан батлуулж, аялал жуулчлал, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлд түшиглэсэн сүм хөгжүүлнэ.

## ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Хөгжих, суралцах, ая тухтай амьдрах орчныг бүрдүүлж, эрүүл, эрдэм боловсролтой иргэнийг хөгжүүлнэ.

### 2.1. ГЭР БҮЛ, ХҮҮХЭД ХАМГААЛАЛ, ХҮН АМ

2.1.1. Гэр бүл болон нийгмийн орчин дахь хүүхэд хамгааллыг сайжруулж, өсвөр үе, залуучуудын нийгмийн оролцоог нэмэгдүүлнэ.

2.1.1.1. Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын "Ирээдүйн эзэд" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.1.1.2. Засгийн газраас хэрэгжүүлж буй өсвөр үе, залуучуудын хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.1.1.3. Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

### Хөдөлмөр халамж

2.1.2. Халамжаас хөдөлмөрт шилжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.

2.1.2.1. Нийгмийн халамжийн зорилтот өрхийн хөдөлмөрийн насын хөдөлмөрийн чадвартай иргэдийг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамруулна.

2.1.2.2. Хувийн хэвшил, ТББ-ын оролцоотой /ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн/ иргэдийг дэмжиж ажиллана.

2.1.2.3. Төсөл хөтөлбөрүүдээр дамжуулан байнгын болон түр ажлын байрыг нэмэгдүүлнэ.

2.1.2.4. Ажил хайгч, ажилгүй иргэнийг ажилд зуучилж хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

2.1.2.5. Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлнэ.

### Нийгмийн даатгал

2.1.3. Сайн дүрүн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлнэ.

2.1.3.1. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажилгүй иргэн, даатгуулагчдад нийгмийн даатгалын үйлчилгээг чанартай, хүртээмжтэй үзүүлнэ.

### Биеийн тамир, спорт

2.1.4. Биеийн тамир, спортын хүртээмжийг сайжруулж, иргэдийн бие бялдрын боловсрол"-ыг дээшлүүлнэ.



- 2.1.4.1. Иргэдэд биеийн тамир, спортын үйлчилгээг үзүүлж, тогтмол хичээллэгчдийн тоог нэмэгдүүлнэ:
- 2.1.4.2. Өсвөрийн шигшээ багийг дэмжин ажиллах
- 2.1.4.3. Үндэсний спорт болон их спортын наадам, тэмцээн уралдаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

## 2.2. БОЛОВСРОЛ

- 2.2.1. Хүүхэд бурийн ялгаатай хэрэгцээнд тулгуурлан тэгш хүртээмжтэй оролцоог дэмжин, сургалтын орчныг сайжруулж, сургалтын чанарыг нэмэгдүүлнэ.
- 2.2.1.1.Бүх шатны боловсролын байгууллагын чанар хүртээмжийг сайжруулна.
- 2.2.1.2.Дэвшилтэд технологийг ашиглаж цахим сургалтын орчныг нэмэгдүүлнэ.
- 2.2.1.3. Багш нарын мэргэшил, чадавхыг сайжруулна.
- 2.2.1.4. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт шаардлагад нийцсэн тэгш боломж бүхий мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлнэ.
- 2.2.1.5. ЕБС, дотуур байр, СӨБ-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.
- 2.2.1.6.Боловсролын салбарын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангасан орчныг бүрдүүлнэ.
- 2.2.1.7. Судалгаанд үндэслэн зарим сургуулийн хэв шинжийг өөрчилнэ.
- 2.2.1.8. Багш нарыг тогтвортой ажиллах нөхцөл боломжоор хангаж, нийгмийн баталгааг сайжруулна.

## 2.3. ЭРҮҮЛ МЭНД

- 2.3.1. Нийгмийн эрүүл мэндийн болон эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.
- 2.3.1.1. Эрүүл амьдралын хэв маяг, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийг дэмжих чиглэлээр иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, зонхилон тохиолдох өвчлөлөөс сэргийлнэ.
- 2.3.1.2. Эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжиж, сэргийлж болох хүүхдийн эндэгдлийг бууруулна.
- 2.3.1.3. Уламжлалт анагаах ухааны тусlamж үйлчилгээг орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлнэ.
- 2.3.1.4. Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх.
- 2.3.1.5. Цахим эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангаж дэвшилтэт технологи телемедицинийг өргөжүүлэх.
- 2.3.1.6. Эмч, мэргэжилтнүүдийн нийгмийн баталгааг сайжруулж, тогтвортой ажиллах нөхцөл боломжоор хангана.
- 2.3.1.7. Эрүүл мэндийн байгууллагуудад шаардлагатай тоног төхөөрөмжийг сайжруулж барилга, автомашины хангалтыг нэмэгдүүлнэ.

## 2.4. ОРОН СУУЦ, ДЭД БҮТЭЦ

- 2.4.1. Эрчим хүчний хэмнэлттэй, ногоон барилга байгууламжийн шаардлага хангасан барилгын тоог нэмэгдүүлж, нийтийн болон амины орон сууц барих санаачилгыг дэмжинэ.
- 2.4.1.1. Төр хувийн хэвшлийн түншлэлээр нийтийн болон амины орон сууц барих санаачилгыг дэмжиж, түрээсийн орон сууцны сан бий болгоно.
- 2.4.1.2. Ногоон барилга, байгууламжийг нэмэгдүүлэхэд төр хувийн хэвшил, иргэдийн хамтын ажиллагааг хангаж ажиллана.
- 2.4.1.3. Нийгмийн үйлчилгээний байгууллагуудын барилга байгууламжийн эрчим хүчний хэмнэлттэй технологид суурилсан зураг төслийг дэмжиж ажиллана.
- 2.4.1.4. Барилга байгууламжийн техникийн хяналт, барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийн үйл ажиллагааг сайжруулж, барилга байгууламжийн чанарыг дээшлүүлнэ.
- 2.4.2. Инженерийн шугам сүлжээнд холбогдсон айл өрхийн тоог нэмэгдүүлнэ.
- 2.4.2.1. Инженерийн шугам сүлжээний төсөл арга хэмжээнүүдийг ашиглалтад оруулж, найдвартай ажиллагааг хангана.
- 2.4.3. Суурин газрын үерийн эрсдэлийг бууруулна.

2.4.3.1. Уерийн эрсдэлийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээг хийж, ус зайдуулах шугам сүлжээг байгуулна.

### ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

Төсөв, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулан, төр, хувийн хэвшлийн түншлэлийн эдийн засгийг бэхжүүлнэ. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах дасан зохицох орон нутгийн чадавхыг сайжруулна.

#### 3.1. ТӨСӨВ, САНХҮҮ

##### Санхүү, хяналт

3.1.1. Төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.1.1.1 Шилэн дансны цахим хуудсаар байгууллагын төсвийн ил тод байдлыг хангаж ажиллана.

3.1.1.2 Санхүүгийн ажилтнуудыг чадавхжуулж, дотоод хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэн төсөвт байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны зөрчлийг бууруулна.

3.1.1.3. Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг сайжруулан, жижиг, дунд, бичил бизнесийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

##### Татвар

3.1.2. Бага, дунд бага орлоготой иргэд болон хуулийн этгээдийг дэмжих татварын бодлогыг хэрэгжүүлж, "Цахим татвар"-ын системийн ашиглалтыг нэмэгдүүлнэ.

3.1.2.1. Татвар төлөгчийн бүртгэлийг бүртгэлийн байгууллагуудтай хамтран бодит цагийн горимоор бүртгэж, цахимжуулах ажлыг эрчимжүүлнэ.

3.1.2.2. Бүх төрлийн татварын тайланг цахимжуулах.

3.1.2.3. Хуульд заасан шаардлагыг хангасан ААН-үүдэд хуулийн дагуу төлсөн татварыг буцаан олгох, хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх боломжийг олгоно.

##### Орон нутгийн өмч

3.1.3. Орон нутгийн өмчийн ашиглалт, үр өгөөжийг нэмэгдүүлэх.

3.1.3.1. Орон нутгийн өмчийн бүртгэл, хяналтыг сайжруулна.

##### Худалдан авах ажиллагаа

3.1.4. Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны тоог нэмэгдүүлж, худалдан авах ажиллагааг ил тод байлгана.

3.1.4.1. Худалдан авах ажиллагаа зохион байгуулах ажилтан, албан тушаалтан, иргэн, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг сургалтад хамруулж мэргэшсэн албан хаагч, иргэдийн тоог нэмэгдүүлнэ.

3.1.4.2. Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодын үйлдвэрлэлийг дэмжиж ажиллана.

#### 3.2. ТӨРӨЛЖСӨН ЭДИЙН ЗАСАГ

3.2.1. Уул уурхайн түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсруулах хүнд үйлдвэрийн төслүүдийг дэмжиж ажиллана.

3.2.1.1. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр Бор-Өндөр суманд үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлыг эхлүүлнэ.

3.2.1.2. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ордыг түшиглэн дотооддоо барилгын материал үйлдвэрлэх хувийн хэвшлийн санал санаачилгыг дэмжинэ.

3.2.2. Зорчигч иргэдийг тав тухтай, аюулгүй тээвэрлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

3.2.2.1. Хот хооронд болон хот доторх зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгчдийг стандартын шаардлага хангуулна.

3.2.2.2. Улс болон орон нутгийн чанартай авто замын сүлжээний ашиглалтын бэлэн байдлыг хангана.

3.2.3. Хэрэглэгчдийг чанартай, найдвартай дулаан хангамж, цахилгаан эрчим хүчээр тасралтгүй хангаж, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.



3.2.3.1. Дулааны станцын дулаан дамжуулах төвүүдийн инженерийн шугам сүлжээний ажлын өргөтгөлийг гүйцэтгүүлж, дулааны станцын 17ш ДДТ-ийн ИШС-ний засвар, шинэчлэлийн ажлыг үе шаттайгаар ашиглалтад оруулна.

3.2.3.2. Багануур-Чингис-Чойбалсан чиглэлийн 220кВ-ын 518 км цахилгаан дамжуулах агаарын шугамын угсралтын ажлыг эхлүүлнэ.

3.2.3.3. Нар, салхины сэргээгдэх эрчим хүчний төслүүдийг төр, хувийн хэвшил, оролцоотойгоор хэрэгжүүлж, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.

3.2.4. "Шинэ хоршоо", "Цагаан алт" хөдөлгөөний хэрэгжүүлж, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын хүртээмжийг нэмэгдүүлнэ.

3.2.4.1. Малын гаралтай түүхий эдийн анхан шатны боловсруулалт хийх хоршоодыг нэмэгдүүлэн, дундын хоршоодын үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

3.2.4.2. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.

3.2.4.3. Ахуйн үйлчилгээний нэгдсэн төвийг байгуулж, үйлчилгээний салбарт ажиллагсдыг чадавхжуулна.

3.2.5. "Атар IV" аян, "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний хэрэгжүүлнэ.

3.2.5.1. "Атар IV" аяны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангана.

3.2.5.2. Хүн амын гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг аюулгүй, чанартай бүтээгдэхүүнээр хангах нөхцөлийг бурдүүлнэ.

3.2.6. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийг дэмжиж малын тоог чанарт шилжүүлж, бэлчээр ашиглалтыг сайжруулна.

3.2.6.1. Бүс нутгийн онцлогт тохирсон эрчимжсэн мал аж ахуйг дэмжинэ.

3.2.6.2. Баталгаажсан үүлдэр, омгийн малын ашиг шимижг нэмэгдүүлнэ.

3.2.6.3. Бэлчээрийг хамгаалж, нөхөн сэргээнэ.

3.2.6.4. Бэлчээр ашиглалтын журмыг хэрэгжүүлэх.

3.2.7. Мал эмнэлгийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж, мал, малын гаралтай хүнсний түүхий эд бүтээгдэхүүний эрүүл, аюулгүй байдлыг хангана.

3.2.7.1. Мал эмнэлгийн үйлчилгээний стандартын шаардлага хангасан зүүн бүсийн мал эмнэлгийн төв лаборатори байгуулна.

3.2.7.2. Мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, мах, сүүнд анхан шатны шинжилгээ хийх мал эмнэлгийн нэгдсэн төвийг сумдад байгуулна.

3.2.7.3. Мал, амьтны халдварт өвчний голомт, шимэгчтэх өвчний гаралт, тархалтыг бууруулж, зарим халдварт өвчний байгалийн халдварлалтыг тогтооно.

3.2.7.4. Малаас хүнд халдварладаг архаг халдварт бруцеллээс өвчнөөр эрүүл сум, баг, малчин өрхийг баталгаажуулж, эрүүл бүсийг бий болгоно.

3.2.8. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний стандартыг сайжруулж, жуулчдын тоог нэмэгдүүлнэ.

3.2.8.1. "Хэntий аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх 2030" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангана.

3.2.8.2. Аялал жуулчлалын цогцолборуудыг эдийн засгийн эргэлтэд оруулна.

3.2.9. Соёлын өвд тулгуурласан аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна

3.2.9.1. Орон нутгийн онцлогт тулгуурласан улс, ОУ-ын чанартай арга хэмжээ, наадмуудыг зохион байгуулна.

3.2.9.2. Аймаг, орон нутгаас төрөн гарсан урлаг, соёлын алдартнуудын уран бүтээлийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх.

3.2.9.3. Соёлын өвийг сурталчилж, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах.

### 3.3. БАЙГАЛ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ

3.3.1. Байгалийн унаган төрх, экосистемийн тогтвортой байдлыг хадгалж, биологийн олон янз байдлыг хамгаална.

3.3.1.1. Тусгай хамгаалалттай газар нутгийг нэмэгдүүлнэ.

3.3.1.2. Ховор амьтан ургамлыг өсгөн үржүүлж, хамгаалж, нөөцөд тохируулан тогтвортой ашиглана.

3.3.1.3. Байгалийн нөөцийн хамтын менежментийг хэрэгжүүлж, олон нийтийн оролцоотой байгаль хамгааллыг сайжруулна.



3.3.1.4. Хариуцлагатай уул уурхайг бий болгох.

3.3.2. Ойгоор бүрхэгдсэн талбай, төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлж, ойн нөөцийг хамгаална.

3.3.2.1. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, "Гучин сая мод" арга хэмжээний хэрэгжилтийг хангана.

3.3.2.2. Ойн хөнөөлт шавжтай тэмцэж ойн хомсдол, доройтол, ой, хээрийн түймрийн эрсдэлийг бууруулна.

3.3.3. Уур амьсгалын өөрчлөлт, байгаль, цаг уурын гаралтай гамшигт үзэгдлийг эрт сээрэмжлүүлж, эрсдэлийг бууруулж, дасан зохицох, тэсвэрлэх чадавхыг бэхжүүлнэ.

3.3.3.1. Аймгийн "Уур амьсгалын өөрчлөлттөд дасан зохицох, сааруулах төлөвлөгөө"-г батлан хэрэгжүүлнэ.

3.3.3.2. Ус, цаг уур, орчны хяналт, мониторингийн сүлжээний хүчин чадлыг сайжруулж, байгаль, цаг уурын гаралтай гамшигт үзэгдлээс эрт сээрэмжлүүлэх мэдээллийн төрөл, чанарыг нэмэгдүүлнэ.

3.3.4. Усны дахин ашиглалт, усан хангамжийг нэмэгдүүлж, усны нөөцийг хамгаална.

3.3.4.1. Усны нөөцийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангана.

3.3.5. Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлж, орчны бохирдлыг бууруулна.

3.3.5.1. Аймгийн хог хаягдлын менежментийн хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.

## ДӨРӨВ. ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

Төрийн цахим шилжилт, үйлчилгээг эрчимжүүлэн, үр ашиг, хүртээмж, ил тод байдлыг нэмэгдүүлэн, чадварлаг төрийн албыг төлөвшүүлж, хүний эрхийг дээдэлсэн, авлигагүй төрийн бодлогыг хэрэгжүүлнэ. Эх оронч сэтгэлгээг бий болгох арга хэмжээг хэрэгжүүлж, улсын нэгдсэн гадаад бодлогыг баримтална.

### 4.1. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

4.1.1. Нийгмийн дэг журам, аюулгүй байдлыг хангаж, нийт гэмт хэргийг 3 хувь бууруулна.

4.1.1.1. Бүх нийтийн эрх зүйн боловсролын хүрээнд хууль тогтоомжийн мэдлэгийг нэмэгдүүлнэ.

4.1.1.2. Архины хор хөнөөлөөс урьдчилан сэргийлж "Архидалтгүй Хэнтий" арга хэмжээг зохион байгуулна.

4.1.1.3. Төрийн архивын баримтын хадгалалт хамгаалалтын аюулгүй байдлыг хангаж ажиллана.

4.1.1.4. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна.

4.1.1.5. Хил хамгаалалтад дэмжлэг үзүүлэн хилийн аюулгүй байдлыг ханггуулна.

4.1.1.6. Хууль сахиулах байгууллага болон хил хамгаалалтад туслах хүчний зөвлөл, терроризмтэй тэмцэх зөвлөлийн Хэнтий аймаг дахь салбар зөвлөлд дэмжлэг үзүүлэх.

### 4.2. АВЛИГАГҮЙ НУТГИЙН ЗАХИРГАА

4.2.1. Аймгийн Шударга байдлын үнэлгээг сайжруулах

4.2.1.1. "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг орон нутгийн онцлогт тохируулан зохион байгуулна.

### 4.3. ТӨРИЙН АЛБА

4.3.1. Мэргэшсэн төрийн албан хаагчдын тоог нэмэгдүүлж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

4.3.1.1. Төрийн албан хаагчдын хэрэгцээ, шаардлагад үндэслэн "Танхимиын болон цахим сургалт"-ын нэгдсэн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.

4.3.1.2. "Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөр" хэрэгжүүлнэ.

4.3.1.3. Нутгийн захиргааны байгууллагуудын үйлчилгээний стандартыг сайжруулна.

4.3.2. Төрийн албан хаагчдыг улс төрөөс ангид тогтвортой ажиллах ил, тод орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

4.3.2.1. Төрийн албан хаагчийн сонгон шалгаруулах үйл ажиллагааг боловсронгуй болгоно.

4.3.2.2. Орон нутгийн засаглалд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх "Иргэдийн оролцоот-Нэг Хэнтий" арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.3.2.3. Иргэдийн хяналт тавих ажиллагааг сайжруулан бодитой, үнэн зөв, тэнцвэртэй мэдээлэл авах, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хангаж, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг ил тод байлгана.



#### 4.4. ЦАХИМ ШИЛЖИЛТ

4.4.1. Цахим засаглал төрийн үйлчилгээг ил тод нээлттэйгээр иргэдэд ойртуулах

4.4.1.1. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, төрөөс үзүүлж буй үйлчилгээ болон E-Mongolia системийн уялдааг сайжруулан, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

4.4.1.2. Иргэн, төр, бизнесийн байгууллагууд цахимаар мэдээлэл солилцох, ашиглах техник технологийн дэд бүтцийг бий болгоно.

4.4.2. Кибер аюулгүй байдлыг хангах талаарх төрөөс авч хэрэгжүүлж буй бодлого шийдвэрийн хэрэгжилтийг сайжруулна.

4.4.2.1. Иргэд олон нийтийг кибер аюулгүй байдлын талаар мэдээ мэдээллээр хангаж, мэдлэгийг дээшлүүлнэ.

4.4.2.2. Төрийн байгууллагад мэдээлэл, харилцаа холбооны технологийн зохистой хэрэглээг нэвтрүүлж, байгууллага хооронд сайн туршлага хуваалцах, сурталчлах арга хэмжээг зохион байгуулна.

4.4.2.3. Хэрэглэгчдийн харилцаа холбоо, сүлжээний тасралтгүй найдвартай ажиллагааг хангаж, өндөр хурдны интернэтэд холбогдох боломжийг бүрдүүлнэ.

#### 4.5. СТАНДАРТ

4.5.1. Хүн амын хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах орчин нөхцөлийг сайжруулна.

4.5.1.1. Зүүн бүсийн хөгжлийн Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдалд тандалт судалгаа, шинжилгээ хийх хүнсний сорилтын лабораторийг шинэчилнэ.

#### 4.6. ГАДААД БОДЛОГО

4.6.1. ОХУ, БНХАУ болон гуравдагч орнуудтай хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

4.6.1.1. ОХУ болон БНХАУ-ын хамтын ажиллагаатай муж, хотуудтай хамтын ажиллагааг сэргээн эрчимжүүлнэ.

4.6.1.2. Гуравдагч орны ижил түвшний Засаг захиргааны нэгжтэй ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

4.6.1.3. Олон улсын болон Нэгдсэн Үндэстний Байгууллага, бус нутгийн түвшний хамтын ажиллагааг улсын гадаад бодлогоор хэрэгжүүлнэ.

#### 4.7. ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТ

4.7.1. Орон нутагт батлан хамгаалах бодлого, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангана.

4.7.1.1. "Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний дагуу нөөц бүрдүүлэх, сэдэвчилсэн сургалт, дадлагыг зохион байгуулж, томилгоот нэгжийн үүрэг гүйцэтгэх нөхцөлийг дээшлүүлнэ.

4.7.1.2. "Хүүхэд, залуучуудад цэрэг, эх оронч үзэл төлөвшүүлэх" арга хэмжээг үе шаттай зохион байгуулна.

4.7.1.3. "Оюутан цэрэг" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

4.7.1.4. Нутаг дэвсгэртээ байрлаж буй анги байгууллагын бие бүрэлдэхүүний ажиллах орчин үүрэг гүйцэтгэх нөхцөлд дэмжлэг үзүүлнэ.

#### 4.8. ГАМШГИЙН ҮЕИЙН БЭЛЭН БАЙДАЛ

4.8.1. Аймаг сумдын гамшигтай тэмцэх чадавхыг нэмэгдүүлнэ.

4.8.1.1 Аймаг сумдын бэлтгэл бэлэн байдлыг дээшлүүлнэ.

4.8.1.2 Гамшгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг чанартай зохион байгуулна.

4.8.1.3 Гамшигтай тэмцэх чадавхыг сайжруулна.

4.8.2. Гамшгийн аюулын үед харилцан ажиллах дадлага, сургуулилтыг нэмэгдүүлэх.

4.8.2.1. "Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төв"-ийг байгуулж дадлага, сургуулилт явуулах орчин нөхцөл бүрдүүлнэ.

4.8.2.2. Гамшгийн эрсдэлийг бууруулах хамтын ажиллагаанд иргэн, хуулийн этгээдийн оролцоог дэмжинэ.